



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 05 өдөр

Дугаар 341

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Орхон АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1.Зам, тээврийн хөгжлийн сайдын ирүүлсэн саналыг үндэслэн Хуягтын Батболдыг “Орхон АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалаас 2018 оны 9 дүгээр сарын 05-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг холбогдох хууль тогтоомжийн дагуу дуусгавар болгох;

1.2.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01/3339 дүгээр албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2018 оны 05/6241 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан Бариаширын Цогтгэрэлийг “Орхон АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар томилж, контрактыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА